



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Монголын Либерал намын улсын бүртгэлийн
мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг
бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, М.Баярмаа, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Монголын Либерал намын улсын бүртгэл дэх мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч П.Соёл-Эрдэнийн илтгэснээр хэлэлцээд,

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын Либерал намын даргын үүрэг гүйцэтгэгч Б.Амгаланбаатараас: “...Намын даргын үүрэг гүйцэтгэгч Б.Амгаланбаатар би өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ намын Удирдах зөвлөлд өгсний дагуу намын Удирдах зөвлөл 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хуралдаж, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Удирдах зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар Э.Оргилыг намын даргаар сонгон, 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн намын 5 дугаар Их хурлаар Э.Оргилыг Монголын Либерал намын даргаар батламжилсан. Мөн намын ерөнхий нарийн бичгийн даргаар Б.Амгаланбаатарыг томилсон. Иймд, Монголын Либерал намын даргаар Эрдэнэсүрэн овогтой Оргилыг бүртгэж өгнө үү” гэх өргөдөл гаргаж,

- Монголын Либерал намын даргын бүртгэлд өөрчлөлт оруулах тухай өргөдөл (1 хуудас)

- Монголын Либерал намын даргын үүрэг гүйцэтгэгч Б.Амгаланбаатараас намын Удирдах зөвлөлд хандан гаргасан хүсэлт (1 хуудас)

- Намын Удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Үүрэг гүйцэтгэгчээс чөлөөлөх тухай” 05/22 дугаар тогтоол (1 хуудас)

- Намын Удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Намын даргаар сонгогдсонд тооцох тухай” 06/22 дугаар тогтоол (1 хуудас)

- Намын Удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Ерөнхий нарийн бичгийн даргыг сонгох тухай” 08/22 дугаар тогтоол (1 хуудас)
- Намын Удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Намын 5 дугаар Их хурлыг товлон зарлах тухай” 10/22 дугаар тогтоол (1 хуудас)
- Монголын Либерал намын 5 дугаар Их хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “5 дугаар Их хурлын бүрэн эрхийг баталгаажуулах тухай” 01/22 дугаар тогтоол (1 хуудас)
- Намын 5 дугаар Их хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Хурлын дарга, тэргүүлэгчдийг сонгох тухай” 02/22 дугаар тогтоол (1 хуудас)
- Намын 5 дугаар Их хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Редакцын комисс байгуулах комисс байгуулах тухай” 03/22 дугаар тогтоол (1 хуудас)
- Намын 5 дугаар Их хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Хуралдааны дэг батлах тухай” 04/22 дугаар тогтоол (1 хуудас)
- Намын 5 дугаар Их хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Хэлэлцэх асуудал батлах тухай” 05/22 дугаартай тогтоол (1 хуудас)
- Намын 5 дугаар Их хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “намын даргаар батламжлах тухай” 06/22 дугаар тогтоол (1 хуудас)
- Намын 5 дугаар Их хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Ерөнхий нарийн бичгийн даргыг батламжлах тухай” 07/22 дугаар тогтоол (1 хуудас)
- Намын 5 дугаар Их хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батламжлах тухай” 08/22 дугаар тогтоол (1 хуудас)
- Намын 5 дугаар Их хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Намын хяналтын ерөнхий хороо байгуулах тухай” 09/22 дугаар тогтоол (1 хуудас)
- Намын Удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” 04/22 дугаар тогтоол (1 хуудас)
- Намын 5 дугаар Их хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэл (4 хуудас)
- Намын Удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэл (5 хуудас)
- Улсын бүртгэлийн гэрчилгээ (эх хувь)
- Улсын тэмдэгтийн хураамж 150,000 төгрөг тушаасан баримт хавсарган ирүүлсэн байна.

ҮНДЭСЛЭХ нь:

Нийт шүүгчийн хуралдаанаас Монголын Либерал намын хүсэлтийг хангаж, намын улсын бүртгэл дэх мэдээлэлд өөрчлөлд оруулж, тус намын даргаар Э.Оргил сонгогдсон болохыг бүртгэж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Нам дотоод асуудлаа ардчилсан зарчмыг баримтлан олонхын саналаар шийдвэрлэх”, 14 дүгээр

зүйлийн 14.1.4-т “Нам хуульд өөрөөр заагаагүй бол үйл ажиллагааныхаа зохион байгуулалтын бүтэц, зорилт, арга хэлбэрээ чөлөөтэй сонгох эрхтэй” гэж заасан, тухайн тохиолдолд хуулийн дээрх заалтыг хүсэлт гаргагчаас хангасан байна.

Тодруулбал, Монголын Либерал намын дүрмийн 3.4.3-т “Намын Их хурал нь намын дарга, дэд дарга, ерөнхий нарийн бичгийн дарга, намын удирдах зөвлөлийн гишүүдийг Удирдах зөвлөлийн саналыг харгалзан батламжилна” гэж заасан, 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр намын Удирдах зөвлөл хуралдаж, олонхийн саналаар Э.Оргилыг тус намын даргаар сонгосныг, 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр намын Их хурал хуралдаж, 100 хувийн саналаар Э.Оргилыг намын даргаар баталжээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д “Улсын дээд шүүх улс төрийн намыг энэ хууль болон бусад хуульд заасны дагуу бүртгэнэ”, 10 дугаар зүйлийн 10.1 -д “Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна” гэж, 10.1.12-т “хуулийн этгээдийн эрх барих этгээдийн гишүүдийг сонгосон, өөрчилсөн тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр, хурлын тэмдэглэл” гэж тус тус зааснаар намын даргад холбогдох аливаа өөрчлөлт нь Улс төрийн намын улсын бүртгэл, хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулгад заавал тусгах, улсын бүртгэлд бүртгэгдэх мэдээлэл мөн байна.

Иймээс Монголын Либерал намын даргаар Э.Оргил сонгогдсон болохыг бүртгэж, намын улсын бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас үзлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1.Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, 10 дугаар зүйлийн 10.1, 10.1.12-т заасныг тус тус баримтлан Монголын Либерал намын даргаар Чонот овгийн Эрдэнэсүрэнгийн Оргил сонгогдсон тухай өөрчлөлтийг Монголын Либерал намын улсын бүртгэлд бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ